# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 26 өдөр Дугаар А/136 Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын
Хөрөнгийг данснаас дансанд шилжүүлэн
бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 4 дүгээр хурлын шийдвэрийн тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бусад үндсэн хөрөнгө, машин тоног төхөөрөмж, батлан хамгаалах цэргийн зориулалттай хэрэгсэл дансанд бүртгэлтэй нийт 5,509,888.05 (таван сая таван зуун есөн мянга найман зуун наян найман төгрөг таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар (Т.Дамбийням)-т зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар (Т.Дамбийням)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

1150500487

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн 01/136 дугаар тушаалын хавсралт

## Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Хан-Уул дүүрэг Цагдаагийн газар

| № | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Бүртгэх анхны | | Дансны нэр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Шилжүүлэх данс | Бүртгэх данс |
| Машин тоног төхөөрөмж | | | | | | | | | |
| 1 | Вогон сууц | 1/1/2019 | сайн | ш | 1 | 237,600.00 | 237,600.00 | Бусад үндсэн хөрөнгө | Тавилга эд хогшил |
| 2 | Асар | 1/1/2019 | сайн | ш | 1 | 604,464.00 | 604,464.00 | Бусад үндсэн хөрөнгө | Тавилга эд хогшил |
| 3 | Уст-56 асар | 1/1/2019 | сайн | ш | 1 | 498,648.00 | 498,648.00 | Бусад үндсэн хөрөнгө | Тавилга эд хогшил |
| 4 | Уст-56 асар | 1/1/2019 | сайн | ш | 1 | 755,527.27 | 755,527.27 | Бусад үндсэн хөрөнгө | Тавилга эд хогшил |
| 5 | Аж ахуйн хашаа | 1/2/2019 | сайн | ш | 1 | 1,573,200.00 | 1,573,200.00 | Бусад үндсэн хөрөнгө | Барилга байгууламж |
| 6 | Хэргийн газрын үзлэгийн үндэс ном | 1/2/2019 | сайн | ш | 2 | 52,920.00 | 105,840.00 | Машин тоног төхөөрөмж | Бичиг хэрэг |
| 7 | Хийн буу | 1/2/2019 | сайн | ш | 4 | 195,207.38 | 780,829.52 | Батлан хамгаалах, цэргийн зориулалтай | Тусгай зориулалтай материал |
| 8 | Хийн буу | 1/2/2019 | сайн | ш | 1 | 195,207.38 | 195,207.38 | Батлан хамгаалах, цэргийн зориулалтай | Тусгай зориулалтай материал |
| 9 | Хийн буу | 1/2/2019 | сайн | ш | 1 | 195,207.38 | 195,207.38 | Батлан хамгаалах, цэргийн зориулалтай | Тусгай зориулалтай материал |
| 10 | Хийн буу | 1/2/2019 | сайн | ш | 1 | 195,207.38 | 195,207.38 | Батлан хамгаалах, цэргийн зориулалтай | Тусгай зориулалтай материал |
| 11 | Хийн буу | 1/2/2019 | сайн | ш | 1 | 368,157.12 | 368,157.12 | Батлан хамгаалах, цэргийн зориулалтай | Тусгай зориулалтай материал |
| Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн | | | | | | | 5,509,888.05 | | |